



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 ~~18~~ оны ~~06~~ дугаар
сарын ~~27~~ -ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.7, 28 дугаар зүйлийн 28.8.2, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг соёрхон батлах тухай хууль”, Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн хооронд 2017 оны 7 дугаар сарын 5-ны өдөр байгуулсан “Санхүүжилтийн хэлэлцээр”-ийг тус тус үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс ТОГТООХ нь:


1. Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хооронд байгуулсан “Санхүүжилтийн хэлэлцээр”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд хэрэгжүүлэх “Хөдөлмөрийн зах зээлийн дэмжих туршилтын хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. “Хөдөлмөрийн зах зээлийн дэмжих туршилтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/-т, мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /П.Хишигжаргал/, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл” хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч /Ц.Нацагдолгор/-т, хэрэгжилтийг хангаж, тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт тус тус даалгасугай.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
САЙД  С.ЧИНЗОРИГ



УЛААНБААТАР ХОТ
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ
ТТГ - 4566

Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн
дарга  Д.ХАДХҮҮ



Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн
2 дугаар тогтоолын хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ДЭМЖИХ ТУРШИЛТЫН ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго

1.1. Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр нь /цаашид хөтөлбөр гэх/ хөдөлмөрийн зах зээлд шилжихэд нь илүүтэй саад, бэрхшээл учирч буй ажилгүй иргэдийг дэмжих хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт, бичил бизнесийн хөгжлийг дэмжих шинэлэг үйлчилгээ, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх шинэлэг арга замыг турших зорилготой болно. Хөтөлбөрийг 2018-2021 онд Олон улсын хөгжлийн ассоциацийн санхүүжилттэйгээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан хэрэгжүүлнэ.

Хоёр. Зорилтот бүлэг

2.1. Энэхүү хөтөлбөрт ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн¹, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн², бичил бизнес эрхлэгч иргэн хамрагдана.

Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Хөтөлбөрийн хүрээнд дараах гурван чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1.1. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт

3.1.2. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээ

3.1.3. Зорилтот бүлгийн иргэдийн тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орон нутгийн санаачилгын төсөл

Дөрөв. Баримтлах зарчим

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дор дурдсан зарчмыг баримтална:

4.1.1. Хөдөлмөрийн зах зээл дээрх мэргэжил, ур чадварын эрэлт, ажил олгогчийн шаардлага болон зорилтот бүлгийн иргэдийн тогтвортой хөдөлмөр эрхлэх хэрэгцээг уялдуулах;

¹ Сургууль завсардсан, хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд, хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан иргэн, хорих ангиас суллагдсан иргэн, 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэн

² Хөдөлмөрийн гэрээ цуцлах мэдэгдэл авсан, эрүүл мэндийн шалтгаанаар ажлаа өөрчлөх шаардлагатай болсон, эрхэлж байсан хувийн аж ахуй нь эрсдэлд орсны улмаас сэргэх боломжгүй болсон тухайгаа аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржид мэдэгдэж, бүртгүүлсэн иргэн.

4.1.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлж, хянаж, үнэлэхдээ үр дүнд суурилсан зарчмыг баримтлах;

4.1.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын хамтын ажиллагааны хүрээ, талуудын эрх, үүрэг тодорхой байх;

4.1.4. Иргэдийг үл ялгаварлах, тэгш боломжоор хангах;

4.1.5. Хэрэгжүүлэх арга хэмжээний нийгэм, байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлох, хязгаарлах, бууруулах;

4.1.6. Авилгаас ангид ажиллах, авилгалаас урьдчилан сэргийлэх³;

4.1.7. Ил тод, нээлттэй ажиллах.

Тав. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт

5.1. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт гэж ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэний тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжлээр сургаж, Монгол Улсын үндэсний мэргэшлийн II түвшний чадамжийг багцаар нь эзэмшүүлэх, иргэний хандлага, төлөвшил, харилцааны ур чадварыг дорвитой дээшлүүлэх, улмаар ажилтай, орлоготой болоход нь шаардлагатай мэдээлэл, дэмжих үйлчилгээ үзүүлэх зэрэг харилцан уялдаатай үйл ажиллагаа буюу сургалт, үйлчилгээний нэгдлийг ойлгоно.

5.2. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтыг зохион байгуулах:

5.2.1. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын чиглэлийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурлан Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

5.2.2. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтыг Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн төвд жилд нэг удаа зохион байгуулна⁴.

5.2.3. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтыг зохион байгуулах сургалтын байгууллагыг Улаанбаатар хотод⁵ Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, орон нутагт⁶ аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн⁷, нээлттэй тендерээр, зохих шалгуурын дагуу сонгон

³Олон улсын Сэргээн босголт, хөгжлийн банк, Олон улсын Хөгжлийн ассоциацийн зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилттэй төслүүдэд баримтлах "Залилан, авлигаас урьдчилан сэргийлж, таслан зогсоох удирдамж"-нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч бүх талууд мөн адил хамаатай болно.

⁴ Сургалтыг сумдад зохион байгуулахгүй. Сумын төвд амьдардаг иргэн хүсвэл аймгийн төвд ирж сургалтад хамрагдах хүсэлтээ гаргах боломжтой бөгөөд хамрагдах тохиолдолд сургалтын зардлаас бусад зардлыг өөрөө хариуцна.

⁵ Төвийн 6 дүүрэг хамаарна.

⁶ 21 аймаг болон алслагдсан 3 дүүрэгт хамаарна.

⁷ "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

шалгаруулж, үр дүнд суурилсан санхүүжилтийн⁸ гэрээ байгуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

5.2.4. Мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий⁹ шаардлага хангасан хувийн хэвшлийн мэргэжлийн сургалтын байгууллага¹⁰, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага сонгон шалгаруулалтад оролцоно. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага сонгон шалгаруулалтад давуу эрх эдлэхгүй.

5.2.5. Сургалтын байгууллагаас ирүүлсэн үнийн санал, сургалтын үр дүнгийн амласан зорилтот түвшин, сургалтын суудлын тоо зэрэг нь сургалтын байгууллагыг сонгон шалгаруулах гол шалгуур үзүүлэлт болно. Сургалтын байгууллагын зүгээс амлах сургалтын үр дүнгийн босго түвшин 70 хувиас доошгүй байна. Сургалтын байгууллага үнийн саналаа боловсруулахдаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас сургалтын чиглэл бүрээр батлах “зардлын дээд хэмжээ”-нээс хэтрүүлэхгүй.

5.2.6. Аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь сургалтын байгууллагыг сонгон шалгаруулсан шийдвэр, үндэслэлийг тухай бүр олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

5.3. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтад хамрагдах иргэнийг сонгох

5.3.1. Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь орон нутгийн хүн ам, зорилтот бүлгийн иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт, түүнд хамрагдах нөхцлийн талаарх мэдээллийг өргөн хүрээнд сурталчилж, түгээнэ.

5.3.2. Сургалтад хамрагдах иргэдийг онооны үнэлгээний аргаар сонгоно. Онооны үнэлгээний арга нь хөдөлмөрийн зах зээлд шилжихэд тодорхой саад бэрхшээлтэй тулгарч буй иргэдийг сургалтад илүүтэй хамруулах зорилготой.

5.3.3. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь сургалтад хамрагдахаар сонгогдсон иргэн бүрийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээнд хамруулж, иргэнд өөрийн хүсэл эрмэлзэл, ажил эрхлэлтийн зорилгоо тодорхойлох, мэргэжлийн сургалтын байгууллагаа сонгоход нь дэмжлэг үзүүлнэ. Түүнчлэн, сургалтын дараа тухайн иргэнд ажил эрхлэлтийн мэдээлэл, зөвлөгөө, зуучлалын үйлчилгээг хэрэгцээнд нь нийцүүлж үр дүнтэй хүргэнэ.

5.3.4. Сургалтын байгууллага нь суралцагч нэг бүртэй гэрээ байгуулж, сургалтын зорьсон үр дүнг хангахын төлөө суралцагчид дэмжлэг үзүүлж, хамтарч

⁸ Үр дүнд суурилсан санхүүжилт гэж сургалтын үр дүнгийн зорилтот түвшний биелэлтийг харгалзан санхүүжилтийн эцсийн төлбөрийг тооцож олгохыг хэлнэ.

⁹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтран баталсан 2016 оны А/216, А/104 тоот “Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам”-ын дагуу эрх авсан сургалтын байгууллага байна.

¹⁰ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын тушаалаар баталсан “Мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх шаардлага хангасан болон гэрчилгээ авсан, сургалт хийгдсэн сургалтын байгууллагуудын нэрсийн жагсаалт”-д орсон сургалтын байгууллага байна. Жагсаалтыг http://hudulmur-halamj.gov.mn/uploads/files/180323-tushaal_negtgel_2017_2018_0323.pdf холбоосоор үзнэ үү.

ажиллана. Суралцагч сургалтын үр шимийг бүрэн хүртэхийн төлөө зүтгэлтэй, тууштай суралцах үүрэг хүлээнэ.

5.3.5. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтад хамрагдсан иргэнд мэргэжлийн болон модульт сургалт, ажлын байрны дадлагын хугацааны туршид хоол, унааны зардлын хөнгөлөлт олгоно.

5.4. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын бүтэц, хөтөлбөр, хугацаа

5.4.1. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт нь а) хандлага, төлөвшил, харилцааны ур чадварын сургалт, б) мэргэжлийн сургалт, в) ажлын байран дээрх дадлага, г) компьютер, цахим орчинд ажиллах анхан шатны мэдлэг, чадвар олгох сургалт, д) хувь хүний санхүүгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалт, е) ажил хайх чадварыг дээшлүүлэх сургалт, ё) төгсөгчийн чадамж, мэргэшлийн түвшинг үнэлэх хөндлөнгийн үнэлгээнд бэлтгэх, ж) сургалтын дараах мэдээлэл, дэмжих үйлчилгээ гэсэн бүрэлдэхүүнтэй байна. Үүнээс а), г), д) сургалтуудыг модульт сургалт гэнэ.

5.4.2. Сургалтын байгууллага нь цогц сургалтын дээрх бүрэлдэхүүн үйл ажиллагааг цогцоор нь, аль нэгийг нь орхигдуулалгүйгээр хэрэгжүүлнэ.

5.4.3. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын үйл явц нь бүхэлдээ суралцагчийн хандлага, төлөвшил, харилцааны ур чадварыг дээшлүүлэхэд онцгойлон анхаарна.

5.4.4. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын (б) бүрэлдэхүүн буюу мэргэжлийн сургалтад зохих журмын дагуу боловсруулж¹¹, баталгаажуулсан¹² чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр ашиглана. Уг хөтөлбөрт суралцагчийн ур чадварын ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний төлөвлөгөөг багтаасан байна. Харин модульт сургалтад чадамжинд суурилсан сургалтын модулиуд ашиглах бөгөөд сургалтын байгууллага модульт сургалт бүрийн хөтөлбөрийг боловсруулж баталгаажуулсан байна¹³.

5.4.5. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт нь суралцаж буй мэргэжлээс хамааран 16-20 долоо хоногийн хугацаатай байна. Үүнээс, мэргэжлийн сургалтын танхимын сургалт 7-9 долоо хоног; ажлын байран дээрх дадлага 7-8 долоо хоног; хандлага, төлөвшил, харилцааны ур чадвар болон компьютер, цахим орчинд ажиллах анхан шатны мэдлэг, чадвар олгох, хувь хүний санхүүгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажил хайх чадварыг дээшлүүлэх сургалтууд нийлээд 2-3 долоо хоногийн хугацаатай байна.

¹¹ "MNS6541:2015 Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага" стандарт болон Хөдөлмөрийн сайдын 2015 оны А\197 тушаалаар батлагдсан "Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн загвар"-т үндэслэн чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулна.

¹² Чадамжид суурилсан мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг Мэргэжлийн боловсрол, сургалтын бүсийн арга зүйн төв, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв дүгнэлт гаргаж баталгаажуулна.

¹³ Чадамжинд суурилсан сургалтын модульт хөтөлбөрт Мэргэжлийн боловсрол, сургалтын бүсийн арга зүйн төв дүгнэлт өгч, баталгаажуулна.

5.4.6. Сургалтын байгууллага нь ажлын байран дээр дадлагажуулах арга хэмжээг зохих шаардлага хангасан аж ахуйн нэгжтэй хамтарч зохион байгуулна. Аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь сургалтын байгууллагаас санал болгосон аж ахуйн нэгжүүд зохих шаардлага хангаж буй эсэхийг хянаж тогтоосны үндсэн дээр гурван талт гэрээ¹⁴ байгуулахыг сургалтын байгууллагад зөвшөөрнө. Сургалтын байгууллага нь гурван талт гэрээний үр дүнг хангахын төлөө аж ахуйн нэгжид шаардлагатай дэмжлэг, зөвлөгөө өгч ажиллана.

5.4.7. Суралцагчийг ажлын байран дээр дадлагажуулахад хамтран ажилласан аж ахуйн нэгжид батлагдсан жишгийн дагуу урамшуулал олгоно. Урамшууллыг дадлагажуулалт дуусгавар болсны дараа аж ахуйн нэгжийн дансанд шилжүүлнэ.

5.4.8. Суралцагчийн чухам ямар чадамжийг сайжруулах, тэдгээрийг гүйцэтгэлийн ямар шалгуураар үнэлэх, гүйцэтгэлийн тухайн үеийн болон дадлагын төгсгөлд хүрэхээр зорьж буй түвшин зэргийг сургалтын байгууллага ба аж ахуйн нэгж хамтран тодорхойлж, гурван талт гэрээнд хавсаргана. Энэ нь гурван талт гэрээний биелэлтийг дүгнэх гол арга хэрэгсэл болно. Ажлын байран дээрх дадлагаар тухайн мэргэшлийн II түвшний багц чадамжийн нэгжийн 50-иас доошгүй хувийг сайжруулахыг зорино.

5.4.9. Аж ахуйн нэгжид олгох урамшууллыг дадлагын үр дүнг үндэслэн олгоно. Суралцагчийн чадамжийн гүйцэтгэлийг дадлагажуулалтын төгсгөлд сургалтын байгууллага ба аж ахуйн нэгж хамтран үнэлнэ. Аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын төлөөлөл уг хамтарсан үнэлгээнд хөндлөнгийн хяналт тавина. Суралцагчийн гүйцэтгэл зорьсон түвшнийхээ 70 хувиас доошгүй түвшинд хангагдсан бол дадлагажуулалтын зорилго биелсэнд тооцож, аж ахуйн нэгжид олгох урамшууллыг бүтэн олгоно. Харин гүйцэтгэлийн түвшин энэ босгыг даваагүй бол ажил олгогчийн урамшууллыг холбогдох аргачлалын дагуу хасч тооцно.

5.4.10. Цогц сургалтын бүрэлдэхүүнд багтсан ажил хайх чадварыг дээшлүүлэх сургалтыг харьяа аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь ажил хайгчдын бодит хэрэгцээ, шаардлагад нийцүүлж боловсруулсан жишиг хөтөлбөр¹⁵-ийн дагуу зохион байгуулж, сургалтын зардлыг хариуцна.

5.4.11. Сургалтын байгууллага нь цогц сургалт дууссаны дараа төгсөгчдийг ажлын байртай болоход нь туслахад чиглэсэн мэдээлэл, зөвлөгөө, шаардлагатай бусад дэмжлэгийг сургалт дуусгавар болсноос хойших 3 сарын туршид үзүүлнэ.

5.4.12. Сургалтын байгууллага нь төгсөгчдийн ажил эрхлэлтийн мөшгих судалгааг төгсөлтөөс хойш 6 сарын дараа явуулж, аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүргүүлнэ.

¹⁴ Аж ахуйн нэгж, сургалтын байгууллага, аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын хооронд байгуулах "Суралцагчийг ажлын байран дээр дадлагажуулахад хамтран ажиллах тухай гурван талт гэрээ"

¹⁵ Жишиг хөтөлбөрийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас боловсруулж, батална.

5.5. Чадамжийн үнэлгээ

5.5.1. Суралцагчийн чадамжийн үнэлгээ нь сургалтын явцын ба төгсөлтийн дараах үнэлгээнээс бүрдэнэ.

5.5.2. Сургалтын байгууллага нь чадамжид суурилсан мэргэжлийн сургалтын хөтөлбөрт тусгасан үнэлгээний төлөвлөгөөний дагуу суралцагчийн чадамж, ур чадварын ахиц дэвшлийг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд ашиглан сургалтын туршид үнэлж, суралцагчийн суралцах үйл явцыг идэвхтэй дэмжиж ажиллана.

5.5.3. Цогц сургалтын төгсөлтийн үнэлгээ хөндлөнгийн үнэлгээ байна. Хөндлөнгийн үнэлгээг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв зохион байгуулж, үнэлгээний үр дүнг мэдээллийн нэгдсэн санд бүртгэж байршуулахаас гадна сургалтын байгууллагад албан бичгээр мэдэгдэнэ.

5.5.4. Цогц сургалтын төгсөгчийн хөндлөнгийн үнэлгээний төлбөрийн тодорхой хэсгийг төгсөгч өөрөө хариуцна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь үнэлгээний төлбөрийн нийт хэмжээ болон төгсөгчийн хариуцах хэмжээг тодорхойлно. Хөндлөнгийн үнэлгээний төлбөрийн төгсөгч хариуцахаас бусад хэсгийг цогц сургалтын санхүүжилтийн багцад багтаан төсөвлөж, хөндлөнгийн үнэлгээ зохион байгуулагдсаны дараа бодит зардалд үндэслэн сургалтын байгууллагад нөхөж олгоно.

5.6. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын санхүүжилт, үр дүн, төлбөр

5.6.1. Цогц сургалтын санхүүжилт нь мэргэжлийн ба модульт сургалтын санхүүжилт, суралцагчид олгох хоол, унааны хөнгөлөлт, суралцагчдыг ажлын байрандаа дадлагажуулсан аж ахуйн нэгжид олгох урамшуулал, чадамжийн үнэлгээний төлбөрөөс бүрдэнэ.

5.6.2. Сургалтын байгууллагатай байгуулах гэрээний санхүүжилт нь мэргэжлийн ба модульт сургалтын үр дүнд суурилсан санхүүжилт, суралцагчид олгох хоол, унааны хөнгөлөлт, төгсөгчийн чадамжийн хөндлөнгийн үнэлгээний төлбөрийн дүнгээс бүрдэнэ. Үр дүнд суурилсан санхүүжилт гэж сургалтын үр дүнгийн амлаж буй зорилтот түвшин хэр биелэгдсэнээс хамааран мэргэжлийн ба модульт сургалтын санхүүжилтийн эцсийн төлбөрийг тооцож олгохыг хэлнэ. Нэг суралцагчид ногдох мэргэжлийн сургалтын зардлын дээд хэмжээ, модульт сургалтын зардлын жишиг хэмжээ, хоол унааны зардлын хөнгөлөлтийн жишиг хэмжээ, ажил олгогчид олгох урамшууллын жишиг хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батална.

5.6.3. Аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаас сургалтын байгууллага болон сургалтад хамрагдах иргэдийг сонгон шалгаруулсны дараа буюу санхүүжилтийн бодит хэрэгцээ, шаардлага тодорхойлогдсоны дараа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь сургалтын төсвийг аймаг, нийслэл, дүүрэгт хуваарилна.

5.6.4. Тухайн сургалтын байгууллагын суралцагчдын нийт тоонд мэргэжлийн 2-дугаар түвшний багц чадамжийг эзэмшсэн нь хөндлөнгийн үнэлгээгээр тогтоогдож, гэрчилгээ авсан төгсөгчийн эзлэх хувиар сургалтын үр дүнг тооцно.

Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын санхүүжилтийн эцсийн төлбөрийг сургалтын үр дүнтэй уялдуулж олгоно.

5.6.5. Хэрэв сургалтын санхүүжилтийн эцсийн төлбөр хийгдсэний дараа тухайн сургалтын байгууллагын төгсөгч хөндлөнгийн үнэлгээнд дахин хамрагдаж, мэргэшлийн 2-дугаар түвшний багц чадамж эзэмшсэнээ баталгаажуулсан бол энэ нь сургалтын байгууллагын зүгээс сургалтын санхүүжилтийн эцсийн төлбөрийг нэмж нэхэмжлэх үндэслэл болохгүй¹⁶.

5.6.6. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтыг амжилттай зохион байгуулах, үр дүнг хангахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага сургалтын байгууллагуудын хүсэлт, хэрэгцээнд нийцүүлэн хамтран зохион байгуулна. Энэ үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг ХЭДС-ийн жил бүрийн төсөвт тусгана.

Зургаа. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээ

6.1. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээ нь бичил бизнес эрхлэгчдийн аж ахуйн тогтвортой үйл ажиллагаа эрхлэх чадавхийг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгох, цаашид тогтвортой хадгалахыг дэмжих зорилготой.

6.2. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээний бүрэлдэхүүн, хамрах хүрээ

6.2.1 Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээ нь а) жижиг зээл хүсэгчдэд зориулсан зээлийн өмнөх сургалт, б) жижиг зээл¹⁷, в) зээлийн дараах санхүүгийн бус дэмжлэгээс бүрдэнэ.

6.2.2 Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг энэхүү хөтөлбөрийн хүрээнд жижиг зээл авсан иргэн бүрт үзүүлнэ.

6.3. Зээлийн өмнөх сургалт

6.3.1 Зээлийн өмнөх сургалт нь зээл хүсэгчдийн бизнесийн санааг хөгжүүлэх, аж ахуй эрхлэх төсөл, төлөвлөгөө боловсруулах ур чадварыг дээшлүүлэх, зээл болон зээлийн батлан даалтад хамрагдахад бүрдүүлэх баримт бичгүүд, зээлийн төслийг сонгон шалгаруулах аргачлал, зээлийн хүүгийн хөнгөлөлт зэргийг тайлбарлан таниулахад чиглэсэн 2 өдрийн сургалт байна.

6.3.2 Энэ сургалтыг үлгэрчилсэн хөтөлбөр, батлагдсан зардлын жишгийг¹⁸ баримтлан хоёр сар тутамд тогтсон хуваарийн дагуу аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага зохион байгуулна.

6.4. Бичил бизнес эрхлэгчид олгох жижиг зээл

¹⁶ Төгсөгч нь хөндлөнгийн үнэлгээнд дахин хамрагдсан төлбөрийг өөрөө хариуцна.

¹⁷ Энэхүү хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийг Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын дагуу олгоно.

¹⁸ Зээлийн өмнөх сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр, зардлын жишгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батална.

6.4.1 Бичил бизнес эрхлэгчид олгох жижиг зээлийн хэмжээ 5-аас 10 хүртэлх сая төгрөг байна. Жижиг зээлийг иргэнд олгох чиглэл түлхүү баримтлах хэдий ч нөхөрлөл, хоршоо, бичил аж ахуйн нэгжид зээл олгож болно. Жижиг зээл авсан иргэдийн 50-иас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна.

6.4.2 Жижиг зээлийг 24 сарын хугацаатай олгоно. Жижиг зээл авсан иргэн, нөхөрлөл хоршоо, аж ахуйн нэгжийг зээлийн үндсэн төлбөрөөс зээлийн хугацааны эхний 2 сард чөлөөлнө.

6.4.3 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх банктай "Багцын батлан даалтын гэрээ" байгуулж, энэхүү хөтөлбөрийн хүрээнд олгох жижиг зээл хүсэгчдийг зээлийн батлан даалтад хамруулна.

6.4.4 Жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх банк болон жижиг зээлийн төслийг шалгаруулахад тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, сонгон шалгаруулах аргачлал, жижиг зээлийн хөрөнгийг аймаг, дүүрэгт хуваарилах аргачлал, жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх банктай байгуулах гэрээний загвар зэргийг Засгийн газрын холбогдох журамд¹⁹ нийцүүлэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батална. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд олгох жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх банкныг сонгон шалгаруулах ажиллагааг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эх үүсвэрээр санхүүжигдэх жижиг зээлийг дамжуулан гүйцэтгэх банкныг сонгон шалгаруулах ажиллагаанаас тусад нь зохион байгуулна. Түүнчлэн, энэхүү хөтөлбөрийн хүрээнд олгох жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх банкны зүгээс сонгон шалгаруулалтад оролцохдоо санал болгох жижиг зээлийн хүүгийн түвшинг тооцоолох аргачлалыг тусад нь боловсруулна.

6.4.5 Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь жижиг зээлийн төслийг урьдчилан шалгаруулах ажлын хэсгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгуулж, бүрэлдэхүүнд нь жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэхээр шалгарсан банкны тухайн орон нутаг дахь салбарын төлөөллийг зайлшгүй багтааж, төслийг урьдчилан шалгаруулах ажиллагааг холбогдох аргачлалын дагуу шударга, ил тод хэрэгжүүлнэ. Жижиг зээлийн төслийг хүлээж авах, урьдчилан шалгаруулах, банкинд тодорхойлолт гаргаж, холбогдох баримт бичгийн хамт хүргүүлэх ажлыг хоёр сар тутамд буюу жилд зургаан удаа тогтсон хуваарийн дагуу тасралтгүй зохион байгуулна.

6.4.6 Жижиг зээлийн төслийг шалгаруулах, хэрэгжүүлэх үйл явцад төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг хязгаарлах, бууруулахад анхаарал хандуулж, хяналт тавьж ажиллана. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам үнэлгээний хүснэгт, зааварчилгаа зэргийг боловсруулна.

6.5. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ

6.5.1 Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ нь 1) бизнес хөгжлийн сургалт (аж ахуй хөгжүүлэлт, санхүүгийн бүртгэл, маркетинг, борлуулалтын чиглэлээр), 2)

¹⁹ Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолоор баталж, 2018 оны 70 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"

бизнесийн зөвлөн туслах үйлчилгээнээс (бүтээгдэхүүн хөгжүүлэлт, сайжруулалт, менежментийн чиглэлээр менторинг үйлчилгээ, арга зүйн зөвлөгөө өгөх) бүрдэнэ.

6.5.2 Зээлийн дараах бизнес хөгжлийн сургалтын үргэлжлэх хугацаа нь 7 хоног, нийт 50-иас доошгүй цагийн хөтөлбөртэй байна. Бизнес хөгжлийн сургалт нь жижиг зээл авсан иргэний тухайлсан хэрэгцээнд нийцсэн байх бөгөөд хүн бүрт ижил байдлаар төлөвлөгдөхгүй. Бизнесийн зөвлөн туслах үйлчилгээ 20-30 цагийн хугацаатай, иргэний тухайлсан хэрэгцээнд нийцсэн байна.

6.5.3 Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг энэхүү хөтөлбөрийн хүрээнд жижиг зээл авсан иргэн бүрт хэрэгцээнд нь нийцүүлэн багцаар нь үзүүлнэ.

6.5.4 Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг мэргэшсэн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд олгох жижиг зээлийн төслийг урьдчилан шалгаруулах ажлын хэсэг нь (.6.4.5-д заасан) зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг хэрэгжүүлэх байгууллагыг тодорхой шаардлага, шалгуураар сонгон шалгаруулна. Бизнес хөгжлийн сургалт, зөвлөн туслах үйлчилгээг багцаар нь хэрэгжүүлэх чадавхитай төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагыг сонгон шалгаруулах чиглэл баримтална.

6.5.5 Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах үйл явц шударга, ил тод явагдана. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь шалгаруулалтын дүн, дэлгэрэнгүй үндэслэлийг ажлын хэсгийн шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор байгууллагынхаа цахим хуудас, мэдээллийн самбар болон бусад арга хэрэгслээр олон нийтэд ил тод мэдээлнэ.

6.5.6 Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний зардлын жишгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батална.

6.5.7 Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг хэрэгжүүлэхээр шалгарсан байгууллагатай гэрээ байгуулж, үйлчилгээнээс гарах үр дүнг тохиролцож, хэрэгжилтэд нь хяналт тавьж, дүгнэж ажиллана.

6.5.8 Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага ба зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэхээр шалгарсан байгууллага нь жижиг зээл авсан иргэний санхүүгийн бус үйлчилгээний хэрэгцээг уг иргэнтэй хамтран тодорхойлж, гурван талт гэрээнд хавсарган, хэрэгжилтийг нь дүгнэж ажиллана. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг жижиг зээл авсан иргэнтэй гурван талт гэрээ байгуулсан өдрөөс хойш 3 сарын хугацаанд хэрэгжүүлнэ.

6.5.9 Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг гүйцэтгэгч байгууллага нь жижиг зээл авсан иргэний хэрэгжүүлж буй төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг хязгаарлаж, бууруулж буй байдалд хяналт тавьж, зөвлөгөө өгч ажиллана.

6.5.10. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь зээл авсан иргэд бие биеэсээ суралцах, туршлагаа хуваалцах, бизнес, харилцаа холбоо, үйлдвэрлэлийн дэвшилтэт технологи, санаачилгын талаарх мэдээлэл түгээх зорилготой бичил бизнес эрхлэгчдийн клуб зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж болно. Ийм үйл ажиллагааны зардалд зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний тухайн жилийн төсвийн 3.0 хүртэлх хувийг зарцуулж болно.

6.5.11. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь зээл авсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулах, зээлдэгчдийн түншлэлийн харилцаа холбоог өргөжүүлэхэд чиглэсэн үзэсгэлэн, яармаг зэрэг үйл ажиллагааг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад хөтөлбөрүүдтэй уялдуулан зохион байгуулна.

Долоо. Зорилтот бүлгийн иргэдийн тогтвортой ажил эрхлэлтийг дэмжих орон нутгийн санаачилгын төсөл

7.1. Зорилтот бүлгийн иргэдийн тогтвортой ажил эрхлэлтийг дэмжих орон нутгийн санаачилгын төсөл (цаашид орон нутгийн санаачилгын төсөл гэх) нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний шинэлэг хэлбэр, арга хэмжээг турших замаар хот суурин газрын ажилгүйдлийг бууруулах, албан бус хэвшилд ажиллаж буй иргэдийн тогтвортой ажил эрхлэлт, амьжиргааг дэмжих зорилготой. Төслийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага санаачлан боловсруулж, хэрэгжүүлнэ.

7.2. Орон нутгийн санаачилгын төсөлд нэг удаа 150.0 хүртэлх сая төгрөгийн буцалтгүй санхүүжүүлт олгоно. Тухайн аймаг орон нутгийн хөгжлийн сан²⁰ болон бусад эх үүсвэрээс нэмэлт санхүүжилт гаргаж болно. Төслийг 2 жил хүртэлх хугацаагаар хэрэгжүүлнэ.

7.3. Орон нутгийн санаачилгын төсөлд ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг хамруулна. Орон нутгийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн бодит нөхцөл, шинж байдал, хөдөлмөрийн зэх зээлийн эрэлт, нийлүүлэлтийн хүчин зүйлийг харгалзан тухайн орон нутаг төслийн зорилтот бүлгээ тодорхойлно.

7.4. Орон нутгийн санаачилгын төслийн үйл ажиллагааны чиглэл,

7.4.1. Орон нутгийн санаачилгын төсөл нь дараах чиглэлийн үйл ажиллагаа байж болно. Үүнд:

7.4.2. Хөдөлмөр зуучлалын дагуу анх удаа ажилд орсон иргэн, өмнө нь ажилд зуучлуулсан ч ажлаасаа халагдсан эсвэл ажлаа орхисон иргэн, эсвэл ажил олоход хүндрэлтэй байсан иргэн ажилд зуучлуулсан бол уг иргэн болон түүний ажил олгогчид тусгайлан анхаарч, зуучлалын дараах зөвлөн туслах үйлчилгээг тодорхой хугацааны турш үзүүлэх замаар иргэний тогтвортой ажил эрхлэлтийг дэмжих арга хэмжээ,

7.4.3. Их дээд, мэргэжлийн боловсролын сургууль төгссөн, бүртгэлтэй ажилгүй залуучуудыг хөдөлмөрийн зах зээлээс удаан хугацаагаар хөндий байлгахгүй, тэдний ур чадвар, авьяасыг ашиглах, хөгжүүлэхийн зэрэгцээ ажлын туршлагыг нь нэмэгдүүлэх, ажил олгогчид таниулах, улмаар ажилд зуучлахад чиглэсэн арга хэмжээ,

7.4.4. Хот суурин газарт амьдардаг, ажил хийгээгүй, сургууль, боловсролын үйлчилгээнд хамрагдаагүй, ажил хайгаагүй буюу идэвхгүй байгаа 25 хүртэлх насны залуучуудын нийгэмшил, ур чадвар, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн арга хэмжээ,

²⁰ Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйл.

7.4.5. Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхэд тусгайлан анхаарсан арга хэмжээ,

7.4.6. Өрхийн аж ахуй эсвэл бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг боловч ХЭДС-аас хэрэгжүүлж буй бусад хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг, жижиг зээл, сургалтын арга хэмжээнд хамрагдаж байгаагүй иргэдэд зориулан ур чадварын богино хугацааны, модульт, практик сургалтыг зохион байгуулж, эрхэлж буй үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, бүтээмжийг ахиулах, орлогыг нь нэмэгдүүлэхэд шууд үр нөлөө үзүүлэх арга хэмжээ,

7.4.7. Албан бус хэлбэрээр ажил, үйлчилгээ эрхэлж буй иргэдийг зохион байгуулалтад оруулах, ур чадварыг нь нэмэгдүүлэх, шаардлагатай мэдээлэл, мэдлэг олгох замаар тэдний үйлчилгээний стандартыг сайжруулж, албан бус хэвшил дэх тогтворгүй, орлого багатай, баталгаа муутай ажил эрхлэлтийг илүү тогтвортой, баталгаатай ажил эрхлэлтэд шилжүүлэхийг дэмжих арга хэмжээ,

7.4.8. Зохих мэдээлэл, мэдлэг, чадвар олгох замаар бичил бизнес эрхлэгчдийг тухайн орон нутагт хөгжиж буй нийлүүлэлт, өртгийн сүлжээнд бодитой холбох, орлогыг нь нэмэгдүүлэх арга хэмжээ,

7.4.9. Тухайн орон нутгийн хүн амын ажилгүй, ажил эрхлэхийг хүсч буй бусад бүлэгт чиглэсэн, хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх бусад арга хэмжээ.

7.5. Орон нутгийн санаачилгын төсөл боловсруулахад баримтлах зарчим, тавигдах шаардлага

7.5.1. Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан газар хэлтэс нь төсөл санаачлан боловсруулж, хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:

7.5.1.1. Судалгаа, мэдээлэл, дүн шинжилгээнд үндэслэж төлөвлөсөн, бодит үр дүнг баримжаалсан, үр дүнг тооцох боломжтой байх,

7.5.1.2. Засгийн газрын хөдөлмөр эрхлэлтийн салбарт баримталж буй бодлогын зорилтууд болон тухайн орон нутгийг хөгжүүлэх урт болон богино хугацааны зорилт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдах,

7.5.1.3. Холбогдох салбар, ажил олгогч, иргэд, төрийн бус байгууллагын үр дүн баримжаалсан хамтын ажиллагааг хангах, бэхжүүлэх,

7.5.1.4. Ажил олгогчид болон иргэдийн идэвхтэй оролцоог хангах,

7.5.1.5 Харилцан уялдаатай, үр нөлөөтэй үйл ажиллагаа хэрэгжүүлэх,

7.5.1.6 Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, бусад арга хэмжээнүүдтэй харилцан уялдаатай хэрэгжих,

7.5.1.7. Ил тод, шударга байдлыг хангаж ажиллах.

7.5.2. Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага төслийн саналаа өөрийн аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжүүлсэн байна.

7.5.3. Төслийн баримт бичигт орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, зорилго, зорилт, хүрэх үр дүн, үр дүнгийн суурь ба зорилтот түвшин, үр шим хүртэх бүлэг, хамтран ажиллах бүтэц, байгууллагууд, хамтын ажиллагааны хэлбэр, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төсөв, үйл ажиллагааны үр дүнгээ тооцох аргачлал зэргийг тодорхой тусгасан байна. Төслийн төсвийг дэлгэрэнгүй, тодорхой задаргаатай боловсруулсан байна.

7.5.4. Орон нутгийн санаачилгын төсөл хэрэгжүүлэхэд нийтийг хамарсан ажил зохион байгуулахгүй, мөн аж ахуйн нэгж байгууллага, ажил олгогч, иргэдэд санхүүгийн дэмжлэг олгохгүй. Гэхдээ, тухайн төслийн зорилтот бүлгийн иргэдийн үр чадварыг хөгжүүлэх зорилгоор ажлын байран дээр дадлагажуулахтай холбогдуулан ажил олгогчид урамшуулал олгох зардлыг тусгаж болно.

7.5.5. Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь орон нутгийн санаачилгын төслийн санхүүжилтийн 7 хүртэлх хувийг дотоод захиргааны ажил, мониторинг, салбар хоорондын зохицуулалт, ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх үйл ажиллагаанд зарцуулж болно. Мөн төслийг хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай бол нэг ажилтныг гэрээгээр ажиллуулах зардлыг тусгаж болно. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний салбарт ажиллаж байсан туршлагыг нь харгалзан гэрээт ажилтныг сонгон шалгаруулж ажиллуулна.

7.6. Орон нутгийн санаачилгын төслийн шалгаруулалт, хугацаа, хэрэгжилт

7.6.1. Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаас санаачлан боловсруулсан төслийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар тодорхой шалгуурын дагуу холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн жилд нэг удаа 3-4 төслийг сонгон шалгаруулж, гэрээ²¹ байгуулан санхүүжүүлж, төслийн хэрэгжилтийн явц, зорьсон үр дүнгийн биелэлтийг дүгнэж ажиллана.

7.6.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь орон нутгийн санаачилгын төслөөр туршигдсан ололт, үр нөлөөтэй арга хэмжээнүүдийн талаар харилцан туршлага хуваалцах, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн сургалт, шинэлэг арга хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудын дунд зохион байгуулж болно. Энэ арга хэмжээнд зориулж нийт орон нутгийн санаачилгын төслийн санхүүжилтэд тухайн жилд төсөвлөсөн хөрөнгийн 3 хүртэлх хувийг зарцуулж болно.

7.6.3. Орон нутгийн санаачилгын төслийг хэрэгжүүлэх тухай гэрээ, тайлангийн загварыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын тушаалаар батална.

Найм. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ, үр дүнгийн шалгуур үзүүлэлт, арга хэрэгслүүд

8.1. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээний тогтолцоо

²¹ Орон нутгийн санаачилгын төсөл хэрэгжүүлэх тухай гэрээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга болон тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга байгуулна.

8.1.1. Энэхүү хөтөлбөрийг хянаж, үнэлэхэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хүрээнд баримтлах хяналт, үнэлгээ, тайлагналтын журмыг мөрдөхийн зэрэгцээ мэдээлэл, тайланг цахимаар хүлээж авах ажиллагаа, хөтөлбөрийн үр дүн, нөлөөллийг тодорхойлох судалгаа зэрэг хяналт, үнэлгээний шинэлэг хэлбэр, арга хэрэгслийг ашиглана.

8.1.2. Хөтөлбөрийн үр дүн, нөлөөллийг тодорхойлох судалгаа, үнэлгээний аргачлалыг боловсруулж, хэрэгжүүлэхэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт оролцоно.

8.2. Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд

8.2.1. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд:

8.2.1.1. Сургалтад хамрагдсан иргэний тоо; хүйсээр

8.2.1.2. Тухайн мэргэжлийн мэргэшлийн 2-дугаар түвшний чадамжийг бүрэн эзэмшсэн нь хөндлөнгийн үнэлгээгээр баталгаажсан иргэдийн тоо, хүйсээр ба нийт сургалтад хамрагдсан иргэдийн тоонд эзлэх хувь (70 хувиас доошгүй), хүйсээр;

8.2.1.3. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтад хамрагдсан иргэдийн сургалтын талаарх сэтгэл хангалуун байдал (80 хувиас доошгүй).

8.2.2. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээний үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд:

8.2.2.1. Жижиг зээл авсан иргэдийн тоо, хүйсээр;

8.2.2.2. Нийт олгогдсон жижиг зээлийн хэмжээ ба нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь,

8.2.2.3. Жижиг зээл авснаас хойш наад зах нь 6 сарын хугацаанд аж ахуйн үйл ажиллагаагаа тогтвортой эрхэлсэн иргэдийн нийт зээлд хамрагдсан иргэдийн тоонд эзлэх хувь (70 хувиас доошгүй), хүйсээр;

8.2.2.4. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээнд хамрагдсан иргэдийн уг үйлчилгээний талаарх сэтгэл хангалуун байдал (80 хувиас доошгүй).

8.2.3. Орон нутгийн санаачилгын төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд²²:

8.2.3.1. Дэмжигдэж хэрэгжсэн орон нутгийн санаачилгын төслийн тоо (12-оос доошгүй);

8.2.3.2. Төсөлд хамрагдсан нийт иргэдийн тоо, хүйсээр;

8.2.3.3. Зуучлалын дараах зөвлөгөө, дэмжих үйлчилгээ авсан нийт зорилтот иргэдийн тоо, хүйсээр, (хөдөлмөр зуучлалын дагуу анх удаа ажилд орсон иргэн, өмнө нь ажилд зуучлуулсан ч ажлаасаа халагдсан эсвэл ажлаа орхисон иргэн, ажил олоход хүндрэлтэй байсан иргэн); мөн эдгээр иргэдийн нийт тоонд эзлэх ажилд

²² Эдгээр үзүүлэлтүүд аймаг, нийслэл, дүүргүүдээс санаачилсан төслийн стратеги, төлөвлөсөн арга хэмжээнээс хамаарна.

зуучлуулснаасаа хойш 4-өөс доошгүй сарын турш ажлаасаа халагдаагүй, ажлаа орхиогүй иргэдийн эзлэх хувь (70-аас доошгүй хувь), хүйсээр;

8.2.3.4. Хөдөлмөрийн зах зээлээс удаан хугацаагаар хөндий байлгахгүй, ур чадвар, авьяасыг ашиглахын зэрэгцээ ажлын туршлагыг нь нэмэгдүүлэх, ажил олгогчид таниулах, ажилд зуучлахад чиглэсэн арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдсан их дээд, мэргэжлийн боловсролын сургуулийг төгсөгч, бүртгэлтэй ажилгүй залуучуудын (15-25 насны) тоо, хүйсээр; мөн эдгээр залуучуудаас ажлын байранд зуучлагдаж, наад зах нь 4-өөс доошгүй сар ажилласан залуучуудын эзлэх хувь (60-аас доошгүй хувь), хүйсээр;

8.2.3.5. Нийгэмшил, ур чадвар, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн арга хэмжээнд хамрагдсан ажил хийгээгүй, сургууль, боловсролын үйлчилгээнд хамрагдаагүй, ажил хайгаагүй буюу идэвхгүй байсан 15-25 хүртэлх насны залуучуудын тоо, хүйсээр;

8.2.3.6. Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхэд тусгайлан анхаарсан арга хэмжээнд хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо, арга хэмжээний үр дүнд ажилтай, орлоготой болсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь (70-аас доошгүй хувь);

8.2.3.7. Ур чадварын богино хугацааны модульт сургалтад хамрагдсан ерхийн аж ахуй эсвэл бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч (ХЭДС-аас хэрэгжүүлж буй бусад хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг, жижиг зээл, сургалтын арга хэмжээнд хамрагдаж байгаагүй) иргэдийн тоо, хүйсээр; үүнээс сургалтаас хойш 3 сар өнгөрсны дараах байдлаар үйлдвэрлэл, үйлчилгээнийх нь чанар, бүтээмж сайжирсан, эсвэл орлого нь мэдэгдэхүйц нэмэгдсэн гэж үзэж буй иргэдийн эзлэх хувь (70-аас доошгүй хувь), хүйсээр;

8.2.3.8. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг зохион байгуулалтад оруулах, ур чадварыг нь нэмэгдүүлэх, тэдний үйлчилгээний стандартыг сайжруулахад чиглэсэн сургалт, бусад шаардлагатай арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо, хүйсээр; эдгээр иргэдээс сургалт, арга хэмжээ дууссанаас хойш 3 сар өнгөрсний дараах байдлаар илүү тогтвортой, зохион байгуулалттай хэлбэрээр хөдөлмөр эрхэлдэг болсон гэж дүгнэж байгаа иргэдийн эзлэх хувь (60-аас доошгүй хувь), хүйсээр;

8.2.3.9. Нийлүүлэлт/өртгийн сүлжээнд холбож орлогыг нь нэмэгдүүлэх сургалт, арга хэмжээнд хамрагдсан бичил бизнес эрхлэгчдийн тоо, хүйсээр; мөн эдгээр иргэдийн дунд эзлэх өртгийн сүлжээнд бодитой холбогдсон иргэдийн хувь, хүйсээр (60-аас доошгүй хувь).

8.3. Хөтөлбөрийн үр дүн, нөлөөллийг хянаж үнэлэх арга хэрэгслүүд

8.3.1. Хөтөлбөрийн үр дүнг хянаж, үнэлэхдээ захиргааны журмаар тогтмол давтамжтай цуглуулах тоо мэдээ, хөтөлбөрийн хэрэгжилтийг газар дээр нь танилцаж цуглуулсан чанарын мэдээлэл, , хөндлөнгийн мөшгих судалгаа, үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, нөлөөллийн үнэлгээ зэрэг арга хэрэгслийг зохистой хэлбэрээр ашиглана.

8.3.2. Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын ашиглах бүртгэл мэдээлэл, үйл ажиллагааны явцын хяналт, тайлангийн маягтуудаар цуглуулах тоо мэдээ нь хөтөлбөрийн хяналт, үнэлгээний чухал эх сурвалж болно. Захиргааны журмаар цуглуулах мэдээллийг хөтөлбөрийн явцын

хяналт төдийгүй үр дүнгийн үнэлгээ, шинжилгээ хийхэд ашиглана. Иймд тэдгээр маягыг боловсруулахдаа мэдээллийн иж бүрэн байдал, харилцан уялдаатай, ашиглахад хялбар, дөхөм байдалд онцгой анхаарна. Холбогдох маягтуудыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар боловсруулж, батална. Бүртгэл мэдээлэл, үйл ажиллагааны явцын хяналтын мэдээ, тайланг хөтөлбөрт оролцогч талуудаас цахим болон биет хэлбэрээр хүлээж авна.

8.3.3. Үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих санхүүгийн бус үйлчилгээний дараа тухай бүрт явуулж, үр дүнг тайлагнахын зэрэгцээ үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулахад ашиглана. Үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг цахим хэлбэрээр зохион байгуулна.

8.3.4. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтыг төгсөгчдийн чадамжийн үнэлгээ хөндлөнгийн үнэлгээ байна.

8.3.5. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтыг төгсөгчдийн мөшгих судалгааг төгсөлтөөс хойш 6 сарын дараа, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих үйлчилгээнд хамрагдсан зээлдэгчдийн мөшгөх судалгааг зээл авснаас хойш 6 сарын дараа хэрэгжүүлнэ²³. Мөшгих судалгааг холбогдох аргачлалын дагуу судалгааны мэргэшсэн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

8.3.6. Үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгаа авах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудаас бүртгэл мэдээлэл, үйл ажиллагааны явцын хяналт, тайлангийн мэдээллийг цахим хэлбэрээр авах техникийн боломжийг бүрдүүлэх ажлыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар хариуцан зохион байгуулна.

8.3.7. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт болон бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээний нөлөөллийн үнэлгээг²⁴ хийнэ. Нөлөөллийн үнэлгээний аргачлалыг тусгайлан боловсруулсны үндсэн дээр хараат бус, мэргэшсэн судалгааны байгууллагаар гүйцэтгүүлнэ.

---ooOoo---

²³ Мөшгих судалгаа нь тухайн арга хэмжээнээс хойш тодорхой хугацааны дараа үр шим хүртэгчдийн нөхцөл байдалд ямар өөрчлөлт гарсныг судална (жишээ нь, хөдөлмөр эрхлэлтийн байдал, ашиг орлого, бизнесийн тогтвортой байдал, хэрэглээнд гарсан өөрчлөлт).

²⁴ Нөлөөллийн үнэлгээ нь үр шим хүртэгчдэд гарсан өөрчлөлтөд тухайн арга хэмжээ хэр нөлөөлж чадсаныг судална.